



Огноо: 2021 оны 02 дугаар сарын 08

**“ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНД КОМПЬЮТЕР, ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ” НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Худалдан авах ажиллагааны албандаа компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх  
Төслийн дугаар: БХДХААА/202101003

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

**Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Худалдан авах ажиллагааны албанад компьютер, тоноог төхөөрөмж”-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.**

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 11 цаг 00 минут-аас өмнө Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем / [Www.tender.gov.mn](http://Www.tender.gov.mn) / цахим хаягаар ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүснэгтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 11 цаг 30 минут-т** нээнэ.


Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул [Www.tender.gov.mn](http://Www.tender.gov.mn) -хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг татаж авна уу.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50,000 / тавин мянган/ төгрөгийг** банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байна.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.- Монгол Улсын гаралтай бараанд дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо, Худалдан авах ажиллагааны алба, 2 давхар-207 тоот өрөө, утас-70491050**



## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - 3.1.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
      - (а) Унийн санал;
      - (б) Унийн боло нийлүүлэлтийн хуваарь;
      - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
      - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
      - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн аудитлагдсан тайланг /2019/ дүгнэлтийн хамт, 2020 оны санхүүгийн тайлан ирүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй ба холбогдох мэдээллийн баазаас дамжуулсан тайлангаас шалгана.</li> </ul> <p>Сүүлийн 2 жилийн /2019, 2020/ аль нэг жилд нь ижил төсөөтэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл / гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн актыг хавсаргах/</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бусад нэмэлт шаардлага;</li> <li>1. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, бараа нийлүүлэх үе шатны хуваарьт багтаан барааг чанартай нийлүүлэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.</li> <li>2. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>3. Татвар, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>4. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг нотолсон мэдэгдэл ирүүлнэ. Хэрэв зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</li> <li>5. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</li> <li>6. Нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулгыг баталгаажуулж ирүүлэх</li> </ul> <p>ТШӨХ-д заасан аль нэг баримт бичиг дутуу ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2021 оны 02-р сарын 22</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn / -ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй болно.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Багахангай дүүрэг, 1-р хороо, хорооны байр, Худалдан авах ажиллагааны алба</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхар, 207 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2021 оны 02-р сарын 22-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх</li> <li>2. Үндсэн үйл ажиллагааны чиглэл- Гадаад, дотоод худалдаа эрхэлдэг байх</li> <li>3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлэх</li> <li>4. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх ба Татварын ерөнхий газрын <a href="http://Www.e-tax.mta.mn">Www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг татаж шалгана.</li> <li>5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлнэ /Өргүй</li> </ol>

	<p>байх/</p> <ol style="list-style-type: none"> <li>6. Харилцагч банкны тодорхойлолт ирүүлнэ. / Өр төлбөргүй байх/</li> <li>7. Үнийн саналыг баталгаажуулж ирүүлнэ / маягтын дагуу/</li> <li>8. Барааны үнийн болон нийлүүлэх хуваарийг баталгаажуулан ирүүлнэ / маягтын дагуу/</li> <li>9. Нийлүүлэх барааны загвар, тодорхойлолтыг фото зургийн хамт хавсаргаж баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>10. ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 14-16 дахь заалтыг хангаж буй эсэх мэдэгдэл ирүүлэх</li> <li>11. Дээрх тодорхойлолтуудыг / албан бичиг/ тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна. Өмнө авсан албан бичиг байвал ирүүлээгүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно.</li> </ol>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багцгүй</i> .

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:** Дүүргийн Худалдан авах ажиллагааны албандаа нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн үзүүлэлтийг хангасан байна. Нэмэлтээр вирусны программ дагалдвал үнэлгээнд харгалзаж үзнэ.
- 2. Баглаа, боодол:** Бараа нь хайрцаг сав, баглаа боодолтой, шинэ байна.
- 3. Бараа хүргэх газар:** Барааг захиалагчийн товлосон газар хүргэж угсарч төрийн банкны бараа, ажил үйлчилгээ хүлээлцэх актаар хүлээлгэн өгч гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулна. Барааг дүүргийн 1-р хороонд байрлах Худалдан авах ажиллагааны албандаа нийлүүлнэ. Материалын дэлгэрэнгүй техникийн тодорхойлолтыг зураг, каталогын хамтаар техникийн саналд хавсарган ирүүлнэ.

№	Тоног төхөөрөмжийн нэр, төрөл	Тоо хэмжээ	Тоног төхөөрөмжийн үзүүлэлт	Тайлбар
1	Суурин компьютер	1	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдлийн Систем - Windows 10 Home</li> <li>• Процессор / CPU: 10th Generation Intel Core i5-10400 processor (up to 4.3GHz, 12MB cache)</li> <li>• Шуурхай санах ой / RAM: 8GB</li> <li>• Багтаамж / HDD: 512GB SSD-с доошгүй байх</li> <li>• CD/DVD уншигч: 8X DVD SuperMulti Double-Layer Drive</li> <li>• Digital Media Card Reader: Digital Media Card Reader -Secure Digital (SD) Card</li> <li>• Wireless: 802.11ac WiFi</li> <li>• Bluetooth: Bluetooth 4.2</li> <li>• Weight: 2.3kg</li> <li>• 21.5" LED Display</li> <li>• Дэлгэцийн харьцаа: 16:9</li> <li>• Нягтрал: 1920 x 1080</li> </ul>	dell-тэй дүйцэхүйц
2	Зөөврийн компьютер	1	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдлийн систем / OS: Windows 10 Home 64-bit</li> <li>• Процессор / CPU: 10th Generation Intel® Core™ i7</li> <li>• Шуурхай санах ой / RAM: 8GB</li> <li>• Дэлгэц / Display: 15.6-inch FHD (1920 x 1080) LED</li> <li>• Багтаамж / HDD: 1TB</li> <li>• Keyboard: full size standart</li> <li>• Интерфэйс: <ul style="list-style-type: none"> <li>• 2 USB 3.2 Gen 1</li> <li>• 1 USB 3.2 Gen 2 Type-C™ (DP/PowerDelivery)</li> <li>• 1 Headphone/Microphone Combo</li> <li>• 1 HDMI 1.4</li> <li>• 1 Power jack</li> </ul> </li> </ul>	Dell-тэй дүйцэхүйц байх

			<ul style="list-style-type: none"> <li>• 1 MicroSD Card Reader</li> <li>• Audio and Speaker: Stereo speakers with Waves MaxxAudio® Pro ALC3204, 2 W x 2 = 4 W total</li> <li>• Камер / Микрофон: 720p at 30 fps HD camera, dual-array microphones</li> <li>• Wireless / Утасгүй сүлжээ: Intel® Wi-Fi 6 2x2 (Gig+) and Bluetooth</li> <li>• Баттерэй: 4-Cell Battery, 53WHR (Integrated)</li> </ul>	
3	Принтер	1	<ul style="list-style-type: none"> <li>• Олон үйлдэлтэй хувилагч /хэвлэх, хувилах, скан / А3, А4 аль алинаар нь үйлдэл хийж болох,</li> <li>• Хар болон өнгөт</li> <li>• 2 талаараа хэвлэдэг байх</li> </ul>	
4	Проектор, дэлгэцийн хамт	1	<ul style="list-style-type: none"> <li>• Нягтаршил- 1280*800</li> <li>• Lumens-3000</li> <li>• Zoom-1*1</li> <li>• Лампны хугацаа-4500 цаг/10000 цаг</li> <li>• Дуу/audio- 3W mono</li> <li>• HDMI/VGA</li> <li>• Дэлгэцийн хэмжээ- 60*60 инч</li> <li>• Хөлтэй/зөөврийн байх/</li> </ul>	

**4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо/ш	Хэм жих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Суурин компьютер	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдлийн Систем - Windows 10 Home</li> <li>• Процессор / CPU: 10th Generation Intel Core i5-10400 processor (up to 4.3GHz, 12MB cache)</li> <li>• Шуурхай санах ой / RAM: 8GB</li> <li>• Багтаамж / HDD: 512GB SSD-с доошгүй байх</li> <li>• CD/DVD уншигч: 8X DVD SuperMulti Double-Layer Drive</li> <li>• Digital Media Card Reader: Digital Media Card Reader -Secure Digital (SD) Card</li> <li>• Wireless: 802.11ac WiFi</li> <li>• Bluetooth: Bluetooth 4.2</li> <li>• Weight: 2.3kg</li> <li>• 21.5" LED Display</li> <li>• Дэлгэцийн харьцаа: 16:9</li> <li>• Нягтрал: 1920 x 1080</li> </ul>	1	ii	БХД-XAAA	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	

Зөөврийн компьютер	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдлийн систем / OS: Windows 10 Home 64-bit</li> <li>Процессор / CPU: 10th Generation Intel® Core™ i7</li> <li>Шуурхай санах ой / RAM: 8GB</li> <li>Дэлгэц / Display: 15.6-inch FHD (1920 x 1080) LED</li> <li>Багтаамж / HDD: 1TB</li> <li>Keyboard: full size standart</li> <li>Интерфэйс:</li> <li>2 USB 3.2 Gen 1</li> <li>1 USB 3.2 Gen 2 Type-C™ (DP/PowerDelivery)</li> <li>1 Headphone/Microphone Combo</li> <li>1 HDMI 1.4</li> <li>1 Power jack</li> <li>1 MicroSD Card Reader</li> <li>Audio and Speaker: Stereo speakers with Waves MaxxAudio® Pro ALC3204, 2 W x 2 = 4 W total</li> <li>Камер / Микрофон: 720p at 30 fps HD camera, dual-array microphones</li> <li>Wireless / Утасгүй сүлжээ: Intel® Wi-Fi 6 2x2 (Gig+) and Bluetooth</li> <li>Баттерэй: 4-Cell Battery, 53Whr (Integrated)</li> </ul>	1	III	БХД-ХААА	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Принтер	<ul style="list-style-type: none"> <li>Олон үйлдэлтэй хувилагч /хэвлэх, хувилах, скан / A3, A4 аль алинаар нь үйлдэл хийж болох,</li> <li>Хар болон өнгөт</li> <li>2 талаараа хэвлэдэг байх</li> </ul>	1	III	БХД-ХААА	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	
Проектор, дэлгэцийн хамт	<ul style="list-style-type: none"> <li>Нягтаршил- 1280*800</li> <li>Lumens-3000</li> <li>Zoom-1*1</li> <li>Лампны хугацаа-4500 цаг/10000 цаг</li> <li>Дуу/audio- 3W mono</li> <li>HDMI/VGA</li> <li>Дэлгэцийн хэмжээ- 60*60 инч</li> <li>Хөлтэй/зөөврийн байх/</li> </ul>	1	III	БХД-ХААА	Гэрээнд заасан хугацаа	Гэрээнд заасан хугацаа	

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[moor]</i> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан moor]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| <b>1. Шалгах болон турших<br/>(ГЕН – 1)</b>  | <b>1.1.</b> [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт<br/>(ГЕН – 2)</b>  | <b>2.1.</b> Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |   |
| <b>3. Баталгаат засвар<br/>(ГЕН-5)</b>   | <b>5.1.</b> Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна.   |
| <b>4. Төлбөр<br/>(ГЕН – 7)</b>   | <b>7.1.</b> Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Захиалагч гэрээний үнийн дунгийн <b>40 хүртэлх</b> хувиар урьдчилгаа төлбөр олгож болно. Барааг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор төлбөрийг шуурхай шилжүүлнэ.   |
| <b>5. Алданги оногдуулах<br/>(ГЕН - 9)<sup>1</sup></b>   | <b>9.1.</b> Алданги оногдуулах хувь: <b>[0.5%]</b>  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дунгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дунг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]